



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2014 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/23

Эрдэнэт


Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 /г/ дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 2 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дэнж багийн өндөр настан Ш.Дашдуламын охин М.Болормаа нь яаралтай бөөр шилжүүлэн суулгах шаардлагатай болсон тул донорын шинжилгээний зардалд нь дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 1000000 /Нэг сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сан, хуваарилагдаагүй бусад зардлын "Ахмад настны сар шинийн хүндэтгэл, нийгмийн халамжийн зөвлөлийн арга хэмжээний зардал"-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ